

1. Сурагч А Facebook Messenger-ээр “Таны аккаунт хаагдах гэж байна. Доорх холбоосоор орж нууц үгээ шинэчилнэ үү.
Холбоос: <http://facebook-security-login.com>” гэсэн мессежийг хүлээн авчээ. Энэ тохиолдолд хамгийн өндөр магадлалтай кибер эрсдэлийг сонгоно уу.
 - A. Facebook систем автоматаар шинэчлэгдэж, шинээр нэвтрэх
 - B. Хэрэглэгчийн хаягт автоматаар хамгаалалтын тохиргоо нэмэгдэх
 - C. Хуурамч мэдээлэл бүхий холбоосоор төхөөрөмжид вирус суух
 - D. Хуурамч холбоосоор нууц мэдээлэл алдагдах
2. Иргэн Б зөөврийн компьютертоо хувийн болон ажлын мэдээллээ хадгалдаг. Иргэн Б-ийн мэдээллийг хамгаалахад шаардагдах физик хамгаалалтын арга замуудыг сонгоно уу.
 1. Зөөврийн дискийг тогтмол солих
 2. Хэрэглэгчийн нууц үг хийх
 3. Зөөлөвчтэй цүнхэнд хийж байх
 4. Файлуудаа цахим болгон хадгалах
 5. Компьютер дээр даралт өгөх зүйл тавихгүй байх
 6. Файлууддаа нэр өгч, эмх цэгцтэй хадгалах
 7. Цахилгааны залгуурыг унтраахдаа салгаж байх
 - A. 2 → 4 → 6
 - B. 1 → 2 → 3
 - C. 3 → 4 → 7
 - D. 3 → 5 → 7
3. Сурагч Анар гадаадын алдартай YouTube сувгийн видеог монгол хэл рүү орчуулж, хадмал оруулан өөрийн Facebook хуудсанд байршуулаад “*Би өөрөө орчуулсан тул одоо миний бүтээл*” гэж тайлбарлав.
Анарын тайлбарын талаарх зөв дүгнэлтийг сонгоно уу.
 - A. Зохиогчийн эрх анхны бүтээгчид хэвээр хадгалагдана.
 - B. Орчуулга хийсэн тул видеоны өмчлөгч болсон.
 - C. Хадмал нэмсэн тул видеог чөлөөтэй ашиглах эрхтэй болсон.
 - D. Нийгмийн сүлжээнд байршуулсан тул зохиогчийн эрх хүчингүй болно.
4. Багш “Алгоритм” сэдвээр хичээл бэлтгэхдээ зохиогчийн эрхийн зөрчилгүй материал ашиглах шаардлагатай болов.

Зохиогчийн эрх нь биежсэн буюу бодит хэлбэрт орсон бүтээлийг хамгаалдаг. Харин санаа, үйл ажиллагааны арга, шинжлэх ухааны үзэл баримтлал нь зохиогчийн эрхээр хамгаалагдахгүй.

 Аль нь зохиогчийн эрхээр хамгаалагдах вэ?
 - A. Алгоритмын санаа
 - B. Пифагорын теорем
 - C. Сурах бичиг дэх тайлбар
 - D. Шинжлэх ухааны зарчим
5. Чөлөөт, нээлттэй эхийн программ хангамжийн сул талыг зөв тодорхойлсон өгүүлбэрүүдийг сонгоно уу.
 1. Мэдээллийн аюулгүй байдал, техник хэрэгслийн үйл ажиллагааны бүрэн байдал алдагдах эрсдэлтэй
 2. Туршилтын хугацаанд үнэгүй ашигладаг
 3. Програмуудыг хэт өндөр үнэ төлж худалдаж авч ашигладаг
 4. Арилжааны програмуудтай харьцуулахад хэрэглээний хувьд цөөн функцтэй
 - A. 1, 2
 - B. 2, 4
 - C. 1, 4
 - D. 2, 3

6. Сурагч А өөрийн хэрэглэж буй зарим программ хангамжуудын гол онцлогийг тодорхойлжээ. Тэдгээрийг программ хангамжийн лицензийн төрөлтэй нь зөв харгалзуулна уу.

1.	 компьютерын үйлдлийн систем.	A.	Арилжааны ПХ - Commercial software
2.	 2D анимэйшн бүтээдэг.	B.	Дундын ПХ - Shareware
3.	 Зураг засварладаг.	C.	Чөлөөт ПХ - Freeware
4.	 Файл шахаж, архивлаж, задалдаг.	D.	Чөлөөт, нээлттэй эхийн ПХ – Free and open source

A. 1a, 2c, 3d, 4b B. 1a, 2d, 3c, 4b C. 1b, 2d, 3c, 4a D. 1b, 2a, 3c, 4d

7. Сурагч А 16, 17, 17, 160, 170, 165 тоонуудыг цуглуулжээ. Эдгээр тоонууд нь ямар ойлголтод хамаарах вэ?

A. Боловсруулсан мэдээлэл
B. Мэдлэг
C. Мэдээлэл
D. Өгөгдөл

8. Сурагч А 16, 17, 17, 160, 170, 165 тоонуудыг цуглуулан хүснэгтэд оруулж утгатай болгов.

Нэр	Нас	Өндөр
Ану	16	160
Болор	17	170
Оюун	17	165

Хүснэгт нь ямар ойлголтод хамаарах вэ?

A. Боловсруулсан өгөгдөл
B. Мэдлэг
C. Мэдээлэл
D. Өгөгдөл

9. Сурагч А Египетийн пирамидын тухай судлан тэмдэглэл бичиж, зураг, дуу, видео мэдээллүүдийг цуглуулжээ. Эдгээр мэдээллийг нэгтгэн танилцуулга бэлтгэх үйл явцыг юу гэж нэрлэх вэ?

A. Багц мэдээлэл боловсруулах
B. Мэдээлэл цуглуулах
C. Өгөгдөл дамжуулах
D. Өгөгдөл, мэдээлэл хадгалах

10. Сурагч А дэлхийн дулаарлын тухай мэдээллүүд цуглуулж, хавтас үүсгэн зохион байгуулжээ. Үүний давуу талыг сонгоно уу.

- ▼ Дэлхийн дулаарал
- Дэлхийн дулаарал
- Баримт бичиг
- Бичлэг
- Зураг

- A. Компьютер хурдан ажиллах
- B. Мэдээллийн хэмжээг багасгах
- C. Мэдээллийн үнэн зөв байдал нэмэгдэх
- D. Мэдээлэл эмх цэгцтэй хадгалагдах

Зураг. Хавтас ба дэд хавтас


11. Сурагч А “Хүннүгийн түүх” сэдвээр багц мэдээлэл бэлтгэхдээ дараах алхмуудыг хийжээ.

1. Интернэтээс мэдээлэл цуглуулав.
2. Интернэтээс зураг, бичлэг татав.
3. Мэдээллийн үнэн зөвийг шалгалгүйгээр танилцуулга бэлтгэв.
4. Бүх материалыг нэг слайд дээр байрлуулав.

Зөв дүгнэлтийг сонгоно уу.

- A. Багц мэдээллийг зөв дарааллын дагуу боловсруулсан.
- B. Бүх материалыг нэг слайд дээр оруулсан нь ойлгомжтой болсон.
- C. Мэдээллийн үнэн зөвийг шалгах алхам дутуу хийгдсэн.
- D. Олон төрлийн мэдээлэл ашигласан тул алдаагүй зөв болсон.


12. Сурагч А MS Excel программ дээр үүсгэсэн хүснэгтэн мэдээллээ MS Word программд оруулав. Сурагчийн ашигласан арга технологийг зөв тайлбарласныг сонгоно уу.



- A. Объектыг холбох ба нэвтрүүлэх технологи нь нэг программд буй мэдээллийг нөгөө программд нэгтгэх боломжийг олгодог.
 - B. Объектыг анх бүтээсэн программтай холбож өгөх технологи нь түр зуурын мэдээллийг ашигладаг.
 - C. OLE клиент технологи нь ашиглаж буй программын мэдээллийг дараагийн программд шилжүүлэх боломжгүй болгодог.
 - D. Программ хооронд мэдээлэл солилцох технологи нь Windows орчинд л мэдээлэл дамжуулах боломжийг олгодог.
13. Сургуулийн сэтгэл зүйч 10-р ангийн сурагчдад зориулсан “Талархал” сэдэвт танилцуулга бэлтгэж, сүүлийн слайдад тайвшруулах ая оруулахаар болжээ. Иймд компьютер дээрх файлуудаас аудио (дуу) файлыг сонгох шаардлагатай болов. Аль файлыг сонгон ашиглах вэ?

- A. sound.jpg
- B. sound.mp3
- C. sound.pptx
- D. sound.wmv


14. Дижитал зураг нь маш олон жижиг элементээс бүрддэг. Эдгээр жижиг элементүүд нийлж тухайн зургийн өнгө, дүрсийг үүсгэдэг.



Зураг. Дижитал зургийн жижиг элементүүд

Дижитал зургийн хамгийн жижиг элементийг сонгоно уу.

- A. Бит
 - B. Пиксель
 - C. Кадр
 - D. KHz
15. Зурагт секунд бүрд гарах кадрын тоог дүрсэлжээ. Энэ нь видео файлын аль хүчин зүйл болохыг сонгоно уу.



Зураг. Видео файлын шинж чанар

- A. Кадрын үзүүлэлт
 - B. Кадрын хэмжээ
 - C. Өнгөний гүн
 - D. Шахалтын арга
16. Сурагч А хөдөлгөөнт зураг (GIF) үүсгэхээр бэлтгэж байна.


GIF зураг нь хэд хэдэн дараалсан кадраас бүрдэж, тэдгээрийг тодорхой хугацаанд ээлжлэн харуулах замаар хөдөлгөөн үүсгэдэг.

Дараах үйлдлүүдийг хөдөлгөөнт зураг үүсгэх зөв дараалалд оруулна уу.

1. Зургийг дарааллаар байрлуулах
2. Кадр бүрд зураг зурж бэлтгэх
3. Кадрын хугацааг тохируулж, хөдөлгөөнийг шалгах
4. GIF файл болгон хадгалах


- A. 1, 2, 3, 4
- B. 1, 3, 4, 2
- C. 2, 1, 3, 4
- D. 2, 1, 4, 3

17. Сурагч Audacity программ ашиглан дуу засварлаж байна. Дууны эхний 20 секундийг таслан авч үлдэх үйлдлийг сонгоно уу. (Зураг)




Зураг: Audacity программд дуу оруулсан байдал

- A. 20 секундээс хойших хэсгийг сонгоод Trim команд дарах
 - B. 20 секундээс хойших хэсгийг сонгоод Selection команд дарах
 - C. Эхний 20 секундийн хэсгийг сонгоод Silence команд дарах
 - D. Эхний 20 секундийн хэсгийг сонгоод Trim команд дарах
18. Сурагч Movie Maker программ ашиглан видео засварлах явцад оруулсан дуу болон видеоны дуу давхцаж сонсогдоод байсан тул видеоны дууг хаахаар шийдэв. Зургийг ажиглаад видеоны дууг хаах командыг сонгоно уу.




Зураг: Видео засварлах хэрэгслүүд

- A. Audio - Video volume - ...
 - B. Audio - Fade out: - ...
 - C. Adjust - Speed: - ...
 - D. Editing - Trim tool - ...
19. Дараах зурагт онлайн хөрвүүлэгч ашиглан аудио файлыг өөр формат руу хөрвүүлж буй үйл явцыг харуулав. Хөрвүүлээгүй зарим төрлийн аудио файлыг Audacity программд шууд оруулах боломжгүй байдаг. Онлайн хөрвүүлэгч ашиглахын давуу талыг сонгоно уу.



- A. Хөрвүүлэгч программ ашигласнаар "Error Importing" цонх нээгдэхгүй бөгөөд бичлэгийг өөрийн хүссэн төрлөөр хөрвүүлэн хадгалах, ашиглах боломжтой.
- B. Хувиргагч программ ашигласнаар эх хувийг заавал устгах ба өөрийн хэрэгцээндээ нийцүүлэн хөрвүүлэн ашиглах боломжтой.
- C. Онлайн хөрвүүлэгч ашиглах нь санхүүгийн хувьд хэмнэлттэй боловч зөвхөн нэг удаа л үнэгүй хөрвүүлэх боломжтой байдаг.
- D. Интернэтийн сүлжээгүй үед ч ашиглаж болох ба хүссэн үедээ хаана ч ашиглах боломжтой ба дууг засварлахад алдааны мэдэгдэл гарч ирэхгүй.

20. MS Access программд өгөгдлийн сангийн мэдээллийг цаасан дээр хэвлэхэд тохиромжтой, эмх цэгцтэй хэлбэрээр харуулах объектыг сонгоно уу. (Зураг)



Зураг. Цаасан дээр хэвлэхэд тохиромжтой хэлбэр

- A. Form / Маягт
B. Report / Тайлан
C. Table / Хүснэгт
D. Query / Асуулга
21. Зурагт өгөгдлийн сангийн хүснэгтийг мөр, багана хэлбэрээр харж, өгөгдөл оруулах боломжтой байдлаар нээжээ.

Дугаар	Огноо	Шөнө	Өдөр	Цаг агаар
1	2026.03.12, пүрэв	-19	-7	Цастай
2	2026.03.13, баасан	-18	-5	Цастай
3	2026.03.14, бямба	-16	-1	Нартай
4	2026.03.15, ням	-13	3	Нартай
5	2026.03.16, даваа	-13	1	Багавтар үүлтэй
6	2026.03.17, мягмар	-20	-8	Үүлэрхэг
7	2026.03.18, лхагва	-16	-3	Салхитай
8	2026.03.19, пүрэв	-16	-1	Багавтар үүлтэй
9	2026.03.20, баасан	-15	2	Нартай
10	2026.03.21, бямба	-10	6	Нартай

Зураг: Цаг агаарын мэдээ хүснэгт

Энэ нь хүснэгтийн ямар горим бэ?

- A. Datasheet View
B. Design View
C. PivotChart View
D. PivotTable View

22. Зурагт үзүүлсэн хүснэгтийн талбаруудыг тохирох өгөгдлийн төрөлтэй зөв харгалзуулна уу.

Дугаар	Огноо	Шөнө	Өдөр	Цаг агаар
1	2026.03.12, пүрэв	-19	-7	Цастай
2	2026.03.13, баасан	-18	-5	Цастай
3	2026.03.14, бямба	-16	-1	Нартай
4	2026.03.15, ням	-13	3	Нартай
5	2026.03.16, даваа	-13	1	Багавтар үүлтэй
6	2026.03.17, мягмар	-20	-8	Үүлэрхэг
7	2026.03.18, лхагва	-16	-3	Салхитай
8	2026.03.19, пүрэв	-16	-1	Багавтар үүлтэй
9	2026.03.20, баасан	-15	2	Нартай
10	2026.03.21, бямба	-10	6	Нартай

Зураг: Цаг агаарын мэдээ хүснэгт

- | | |
|---------------|--------------|
| 1. Data/Time | A. Цаг агаар |
| 2. Autonumber | B. Өдөр |
| 3. Number | C. Дугаар |
| 4. Short Text | D. Огноо |

- A. 1d, 2b, 3c, 4a
B. 1b, 2a, 3d, 4c
C. 1d, 2c, 3b, 4a
D. 1b, 2d, 3a, 4c

23. Цаг агаарын мэдээ хүснэгтийн **Шөнө** талбарт:

- Validation Rule: **<= 50 And >= -60**
- Validation Text: **Цаг агаарын хэмийг зөв оруулна уу.**

гэсэн тохиргоо хийжээ. (Зураг)

Field Name	Data Type	Description (Optional)
ID	AutoNumber	
Огноо	Date/Time	
Шөнө	Number	
Өдөр	Number	
Цаг агаар	Short Text	


Field Properties	
General	Lookup
Field Size	Integer
Format	
Decimal Places	Auto
Input Mask	
Caption	
Default Value	0
Validation Rule	<=50 And >=-60
Validation Text	Цаг агаарын хэмийг зөв оруулна уу.
Required	No
Indexed	No
Text Align	General

Зураг: Өгөгдлийн сангийн талбарын шинж чанар

Тус талбарт аль утгыг оруулбал анхааруулга бичвэр гарч ирэх вэ?

- A. -50
B. -60
C. 50
D. 60


24. **Өдөр** талбарт утга оруулаагүй үед “You must enter a value in the ‘Цаг агаарын мэдээ.Өдөр’ field.” гэсэн анхааруулга гарчээ.



Тухайн талбарыг заавал утгатай байхаар тохируулсан шинж чанарыг сонгоно уу.

- A. Indexed: No
- B. Required: Yes
- C. Indexed: Yes
- D. Required: No

25. **Цаг агаар** талбарт **Field Size = 25** гэж тохируулжээ. Үүний талаарх зөв дүгнэлтийг сонгоно уу.



- A. Талбарын авах анхны утга 25 байна.
- B. Талбарт зөвхөн 25 тоо оруулах боломжтой.
- C. Талбарт зөвхөн 25 мөр мэдээлэл хадгалах боломжтой.
- D. Талбарт хамгийн ихдээ 25 тэмдэгт бичих боломжтой.